



**ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2014 оны 11 сарын 18 өдөр

Дугаар А/13


Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Сангийн сайдын 2011 оны 132 дугаар тушаалаар баталсан Төрийн албан хаагчийн албан томилолтын зардлын хэмжээ, 188 дугаар тушаалаар баталсан Гадаад томилолтын зардлын хэмжээ, Байгууллагын дотоод журмын 5.9 заалт, Байгууллагын Даргын зөвлөлийн 10 дугаар сарын 02-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын ажилтнуудын албан томилолтоор ажиллах журмыг хавсралтаар баталсугай.
2. Дээрх журмыг 2014 оны 11 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн мөрдөж, санхүүжилтийн зардлыг хууль тогтоомжинд нийцүүлэн гаргаж ажиллахыг Нягтлан бодогч /Г.Батням/-т зөвшөөрсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Үйл ажиллагааны албаны дарга, хүний нөөцийн менежер /Л.Мөнхтуяад/-т даалгасугай.

ДАРГА



М. ГОНЧИГЖАВ